



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/493

Номгон

Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт,
Хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан
төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, "Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын "Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах тухай" 2024 оны 05 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, салбарын хэмжээнд чанартай, үр дүнтэй зохион байгуулан хугацаанд нь тайлагнахыг газар, хэлтэс, агентлагийн дарга, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3.Төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн 11 дүгээр сарын 01-ний дотор Засаг даргад танилцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Мандал)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал) - д даалгасугай.



ДАРГА

Д. МӨНХСАЙХАН

624211233

Аймгийн Засаг даргын *2024* оны *09* дүгээр сарын *12* -ны өдрийн *449* дугаар захирамжийн хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2024-2025 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Албан даалгаварын зорилт арга хэмжээ	Хэрэгжүүлэх ажил арга хэмжээ	Шаардагд ах хөрөнгийн хэмжээ	Хөрөнгийн эх үүсвэр	Хугацаа	Хариуцан Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр							
1	Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулах, сумдыг мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллах	Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэх хангах сумын ажлын хэсгийг томилуулах, нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулах, биелэлтэнд нь хяналт тавин ажиллах	-	ОНТ	Тухай бүр	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын ЗДТГ
2	Отор нүүдлийг чанартай зохион байгуулах, отрын судалгааг нарийвчлан гаргах, улсын тусгай хэрэгцээний отрын бүсэд орох, гарах хөдөлгөөнийг цахимжуулах, нэгдсэн мэдээллийн сан үүсгэж ил тод болгох, холбогдох гэрээ хэлэлцээрийг байгуулан дээрх асуудлыг тухай бүр шийдвэрлэх	Улсын тусгай хэрэгцээний отрын бүс нутаг, хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай газарт отроор өвөлжиж, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргах, гэрээ байгуулсаны үндсэн дээр отор хийх	-	-	Тухай бүр	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Аймаг дундын Отрын бүс нутгийн Захиргаа, Сумдын ЗДТГ
3	Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулах, сумдыг мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллах	Бусад аймаг, сумын нутагт отор нүүдэл хийх малчдын судалгааг нарийвчлан гаргах, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан малыг отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах	0.5 сая төгрөг	Байгууллагын төсөв	Тухай бүр	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	
4		Нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг гамшгийн үед ашиглах нөөц бэлчээрээр авах	-	-	09-10 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ
5		Отроор нүүдэллэж байгаа малчин өрхийг тухайн нутаг захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээг үзүүлж ажиллах	-	-	09-10 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ
6		Өвс тэжээлийн нөөц, борлуулалтын үнийн талаарх мэдээллийг малчид, мал бүхий иргэдэд түргэн шуурхай хүргэх, өвс тэжээлээр тасалдуулахгүй байх арга хэмжээг зохион байгуулах	-	-	Тухай бүр	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ
7	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцөд 200 тн өвс, 100 тн тэжээл, сум тус бүр 30 тн өвс, 30 тн тэжээлийг бэлтгэх, малчдын шаардлагатай өвс, тэжээлийг технологит хугацаанд зайлшгүй багтаан бэлтгүүлэх, хяналт тавих	Аймаг, сумын ОНХС		ОНТ	09-10 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Сум дундын ойн анги, Сумдын ЗДТГ
8	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцөд 200 тн өвс, 100 тн тэжээл, сум тус бүр 30 тн өвс, 30 тн тэжээл зайлшгүй бэлтгэн нөөцлөх	Хадлан тэжээл бэлтгэх техник тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авч ажиллан сумын, өвс тэжээлийн аюулгүйн нөөц заавал бүрдүүлэх, мэдээлэл арга зүйгээр хангах	-	-	09-10 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ
9		Зарим шаардлагатай хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх хадлан бэлтгэх гэрээ хэлэлцээр хийж зохицуулах	-	-	09-10 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8		
10		Хадлан, гар тэжээл бэлтгэх ажлыг технологит хугацаанд хийж гүйцэтгүүлэх	-	-	09-10 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ	
11	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцөд 200 тн өвс, 100 тн тэжээл, сум тус бүр 30 тн өвс, 30 тн тэжээл зайлшгүй бэлтгэн нөөцлөх	Сум, малчдын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бүрэн бэлтгүүлж, анхан шатны нэгжид байршуулах, үлдэгдэл өвс, тэжээлийг хэмжээг нарийвчлан гаргаж, чанарын үнэлгээ хийх,	-	-	09-10 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ	
12	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцөд 200 тн өвс, 100 тн тэжээл, сум тус бүр 30 тн өвс, 30 тн тэжээл зайлшгүй бэлтгэн нөөцлөх	Малчдын өвөлжилт, хаваржилтын хувийн бэлтгэлийг хангуулах, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор бүсчилсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах	5,0 төгрөг	сая	Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардал	10 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	СЗДТГ
13	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцөд 200 тн өвс, 100 тн тэжээл, сум тус бүр 30 тн өвс, 30 тн тэжээл зайлшгүй бэлтгэн нөөцлөх	Малын хашаа хороо, саравч засварлах, шинээр барих, хүрэлцээг нэмэгдүүлэх, бууц хэвтрийг хатаах, ариутгах ажлыг чанартай зохион байгуулж, цаг хүндэрсэн үед хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээл, түлээ түлшээ нөөцлөх, хоол хүнс, хувцас хэрэглэл, эм хэрэгсэл зэргийг базааж өвөлжилтийн бэлтгэлээ сайтар хангахыг малчин өрх бүрд анхааруулах	-	-	09-10 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ	
14	Хөдөө аж ахуйн салбарын 2024-2025 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн аюулгүйн нөөцөд 200 тн өвс, 100 тн тэжээл, сум тус бүр 30 тн өвс, 30 тн тэжээл зайлшгүй бэлтгэн нөөцлөх	Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж орлого бүрдүүлэлтийг ил тод болгох, орлогын эх үүсвэрийг хууль тогтоомжид заасны дагуу эрэмбэлэн зарцуулахад мэдээлэл арга зүйгээр хангаж ажиллах	-	-	09-11 сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ	
15	Аймгийн төвийн хүн амын хүнсний хэрэгцээний 2025 оны хаврын улирлын мах	Аймгийн төвийн хүн амын хүнсний хэрэгцээний 2025 оны хаврын улирлын мах нөөцлөх ажлыг зохион байгуулах	-	-	09-12 сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Мал эмнэлгийн газар, Сумдын ЗДТГ ААН	

1	2	3	4	5	6	7	8	
	нөөцлөх ажлыг зохион байгуулах.							
16	МАН-н салбарын эрсдэлийг бууруулах, малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, тэжээл үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, гадаад зээл тусламжийн эх үүсвэрийг ашиглах боломжийг судлан арга хэмжээ авах.	Ургацын урьдчилсан балансад үндэслэн тэжээлийн хангамж өвөлжих малын тоог тодорхойлсоны үндсэн дээр мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулах, малыг эдийн засгийн эргэлтэд оруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	-	-	Тухай бүр	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Мал эмнэлгийн газар, Сумдын ЗДТГ
17	Цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан ургац хураалтын бэлтгэл ажлыг	Цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан ургац хураалтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх, ургацын	0.5 сая төгрөг	Байгууллагын төсөв	09-10 сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ
18	эрчимжүүлэх, ургацын урьдчилсан балансыг 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор таримлын төрөл тус бүрээр нарийвчлан гаргах, тэжээлийн хангамжийг тооцох	урьдчилсан балансад үндэслэн тэжээлийн хангамжийг тооцох						
19	Бэлчээрийн ургамал хамгааллын ажлыг технологийн дагуу чанартай зохион байгуулж, ашиглалт, хамгаалалтыг нэмэгдүүлэх	Бэлчээрийн ургамал хамгааллын ажлыг технологийн дагуу чанартай зохион байгуулах	-	-	09-11 дүээг сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ
20	Усгүйгээс ашиглахгүй байгаа бэлчээрийг эргэлтэд оруулах зорилгоор геофизикийн хайгуул хийх, уст цэг	Усгүйгээр ашиглахгүй байгаа бэлчээрийг эргэлтэд оруулах зорилгоор геофизикийн хайгуул хийх, уст цэг тогтоох ажлыг зохион байгуулж шинээр гаргах,	-	-	09-12 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8
	тогтоох ажлыг зохион байгуулж шинээр гаргах, худгийн нөөц цэгийн тоог нэмэгдүүлэх, инженерийн хийцтэй худгийн чанар, өмчийн бүртгэлд хяналт тавих	инженерийн хийцтэй худгийн чанар өмчийн бүртгэлд хяналт тавих.					
21	тоог нэмэгдүүлэх, инженерийн хийцтэй худгийн чанар, өмчийн бүртгэлд хяналт тавих	Худаг уст цэг, хашаа хорооны хүрэлцээ хангамжийн судалгааг баг малчин өрх бүрээр гаргах, өөрийн хөрөнгөөр бэлчээрт уст цэг гаргасан малчин өрхийг урамшуулах	-	-	09-12 дугаар сар	Хүнс, аж газар	хөдөө ахуйн Сумдын ЗДТГ
22	Намрын ургац хураалт, хадлан тэжээлийн бэлтгэл болон өвөл хаврын улирлын тэжээлийн хэрэгцээ хангамжид үндэслэн дотоодод бэлтгэсэн өвс тэжээл, хивэгний импортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	Намрын ургац хураалт хадлан тэжээлийн бэлтгэл болон өвөл хаврын улирлын тэжээлийн хэрэгцээ хангамжид үндэслэн өвс тэжээл, хивэгний арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	-	-	Тухай бүр	Хүнс, аж газар	хөдөө ахуйн Сум дундын анги, Сумдын ЗДТГ
23	Ургац хураалтад ажиллах хүч хүч, техникийн бэлэн байдал зохион байгуулалтыг бүрэн хангуулах, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацыг хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх.	Ургац хураалтад ажиллах хүч хүч техник, техникийн бэлэн байдал зохион байгуулалтыг бүрэн хангуулах цаг агаарын гамшигт үзэгдлээс ургац, мал сүргийг хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх.	-	-	Жилдээ	Хүнс, аж газар	хөдөө ахуйн Ус, цаг уур орчны шинжилгээний төв
24	Ургац хураалтад ажиллах хүч хүч, техникийн бэлэн байдал зохион байгуулалтыг бүрэн хангуулах, цаг агаарын гамшигт үзэгдлээс ургацыг хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх.	Ургац хураалт болон мал, мах бэлтгэлийн үед замын хяналтын цэгийн хяналт шалгалтыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран шуурхай хэрэгжүүлж, хүндрэл чирэгдлийг багасгах	-	-	Жилдээ	Хүнс, аж газар	хөдөө ахуйн Цагдаагийн газар
25	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол, "Атар-4 тариалангийн	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол, "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяныг зарлах тухай" ЗГ-ын 2019 оны 476 дугаар тогтоолын хэрэгжилтийг	-	-	2025 оны II улирал	Хүнс, аж газар	хөдөө ахуйн Сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8
	тогтвортой хөгжлийн аяныг зарлах тухай” ЗГ-ын 2019 оны 476 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд атар газрыг тариаланд шилжүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах	эрчимжүүлэх хүрээнд атар газрыг тариаланд шилжүүлэх ажлыг орон нутгийн түвшинд зохион байгуулах					
26	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах	“Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хэрэгжүүлэх төслийг орон нутгийн хөгжлийн болон бэлчээр ашиглалт, газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан мал аж ахуйн салбарын үндсэн хөрөнгө, бүтээн байгуулалтын чиглэлд хандуулах	-	-	Жилдээ	Хүнс, аж газар хөдөө ахуйн	СЗДТГ
27	Амьд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах зориулалт бүхий төвлөрсөн зах, худалдааны төвийн үйл ажиллагааг чанаржуулах, хяналт тавих	Амьд мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан борлуулах зориулалт бүхий төвлөрсөн зах, худалдааны төвийн үйл ажиллагааг чанаржуулах, хяналт тавих	-	-	2025.4 сар	Хүнс, аж газар хөдөө ахуйн	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Баянхонгор сумын ЗДТГ
28	Арилжааны зориулалтаар байгалийн хадлан бэлтгэх гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийн гэрээний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээг дүгнэх, хадлангийн талбайг	Арилжааны зориулалтаар байгалийн хадлан бэлтгэх гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгжийн гэрээний гүйцэтгэлд хяналт тавих, гэрээг дүгнэх, хадлангийн талбайг цэвэрлүүлэх, хяналт тавих	-	-	IV улирал	Хүнс, аж газар хөдөө ахуйн	Сумын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8
	цэвэрлүүлэх, хяналт тавих						
29	Мал сүргийг технологит хугацаанд ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг тогтмолжуулах, малын үзлэг ангилалтыг технологийн дагуу хийж, стандартын шаардлага хангахгүй үржлийн малын 10 хүртэлх, дундаас доош тарга хүчтэй, эр сувай малын 50 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, улмаар иргэдийн хүнсний хэрэгцээт махны нөөцийг нэмэгдүүлэх	Мал сүргийг технологит хугацаанд ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг тогтмолжуулах, малын үзлэг ангилалтыг технологийн дагуу хийж, стандартын шаардлага хангахгүй үржлийн малын 10 хүртэлх, дундаас доош тарга хүчтэй, эр сувай малын 50 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, улмаар иргэдийн хүнсний хэрэгцээт махны нөөцийг нэмэгдүүлэх	19,0 төгрөг сая	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	09-11 дүгээр сар	Хүнс, аж газар хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ
30	Хээлтүүлэгчийн үзлэг, ангилалт, зааглалыг чанартай гүйцэтгүүлж, дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, хээлтүүлгийн ажлыг технологийн хугацаанд хийж хэрэгжүүлэх	Хээлтүүлэгчийн үзлэг, ангилалт, зааглалыг чанартай гүйцэтгүүлж, дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, хээлтүүлгийн ажлыг технологийн хугацаанд хийж хэрэгжүүлэх	19,0 төгрөг сая	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	09-11 дүгээр сар	Хүнс, аж газар хөдөө ахуйн	Сумдын ЗДТГ
Мал эмнэлгийн чиглэлээр							
31	Малын отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион	Отроор явж буй мал сүргийн шилжилт хөдөлгөөнийг батлагдсан маршрутын дагуу явуулах, мал эмнэлгийн гэрчилгээнд үндэслэн хүлээн авах	-	-	Байнга	Мал эмнэлгийн газар	Сумдын ЗДТГ
32	болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион	Гарал үүсэл тодорхойгүй, халдварт болон гоц халдварт өвчин дэгдэж болзошгүй малын шилжилт	-	-	Байнга	Мал эмнэлгийн газар	Цагдаагийн газар

1	2	3	4	5	6	7	8
33	байгуулах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах	хөдөлгөөнд хязгаарлалт тогтоож, хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах Гадны аймаг сумын нутаг дэвсгэрт отор нүүдэл хийж байгаа малчин өрхийг тухайн нутаг захиргааны байгууллага болон (Хөдөө аж ахуйн тасагт) бүртгүүлж, МЭНС-2.0-г үндэслэн мал эмнэлгийн дуудлага үйлчилгээг хүртээмжтэй хүргэж ажиллах.	-	-	Байнга	Мал эмнэлгийн газар	Сумдын ЗДТГ
34	2.2.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн хугацаанд чанартай байгуулж, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хүртээмжтэй хангах, нөөцийг бүрдүүлэх	1.Гоц халдварт, халдварт, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн хэмжээнд чанартай зохион байгуулж ажиллах.	800 сая	Улсын болон орон нутгийн төсөв	9-10 дугаар сар	Мал эмнэлгийн газар	Сумдын ЗДТГ
35		Мал эмнэлгийн дуудлага үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх.	800 сая	Улсын болон орон нутгийн төсөв	3-10 сар	МЭГ	Сумдын ЗДТГ, МЭТ, ХААТ
36	Малын гоц халдварт шүлхий өвчингүй, тайван байдлыг хадгалах, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах, шаардлагатай тохиолдолд хязгаарлах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэх	Гоц халдварт шүлхий өвчингүй, тайван байдлыг хадгалах, МЭНС 2.0-г үндэслэн малын шилжилт хөдөлгөөнийг хянах, гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд хариу арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх.	-	-	Байнга	Мал эмнэлгийн газар	Сумдын ЗДТГ
37	Мал эмнэлгийн үйлчилгээг шуурхай, чанартай зохион	Мал эмнэлгийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах	-	-	Байнга	Мал эмнэлгийн газар	Сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8
38	байгуулах, хот суурин газарт нэвтрэх мал, мах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан эсэхийг нягталж, Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд олгож буй мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт тавьж баталгаажуулах.	-	-	Байнга	Мал эмнэлгийн газар	Сумдын ЗДТГ
	вакцинжуулалт, тарилга, туулгалтын хугацааг сайтар хянах, тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх зам дагуух орон нутгийн чанартай хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	Орон нутгийн чанартай зам дагуух хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлж тээврийн хэрэгслийн халдваргүйтгэлийг тогтмол хийж ажиллах	-	-	Байнга	Мал эмнэлгийн газар	Сумдын ЗДТГ
	вакцинжуулалт, тарилга, туулгалтын хугацааг сайтар хянах, тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх зам дагуух орон нутгийн чанартай хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	Харьяалах нутаг дэвсгэртээ гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах	-	-	Байнга	Мал эмнэлгийн газар	Сумдын ЗДТГ
Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр							
39	Ган, зудын эрсдэлийн үнэлгээ	Ган, зудын эрсдэлийн үнэлгээ хийж хариу арга хэмжээний төлөвлөгөөг нарийвчлан хийж, үнэлгээнд тулгуурласан эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-	-	09 дүгээр сар	Онцгой байдлын газар	-
40	Зам даваа хаагдсан үед бэлэн байдлыг хангах	Өвөл, хаврын улиралд цаг агаарын хүндрэлтэй нөхцөлөөс шалтгаалан зам даваа хаагдах, халтиргаа гулгаа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах, машин техник, хүн хүчний бэлэн байдлыг хангах	-	-	Тухай бүр	Онцгой байдлын газар	Авто тээврийн төв
41		Ургац хураалт болон өвс, тэжээл татан авах, өвөлжилт, хаваржилт хүндэрсэн үед малчин өрхүүдэд тусламж үзүүлэх, хаагдсан авто зам болон давааг нээхэд шаардагдах газрын тосны бүтээгдэхүүний импортыг тасалдуулахгүй нөөцийг хангах,	-	-	Тухай бүр	Онцгой байдлын газар	Авто тээврийн төв

1	2	3	4	5	6	7	8
		түлш шатахуунаар тасралтгүй хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх					
42	Отроор яваа малчид, зорилтот бүлгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах	Өрхийн эрүүл мэндийн төв болон багийн эмч нарын эргэлтийг сайжруулах алслагдсан бүс нутагт отроор яваа иргэдэд тусламж үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх	-	-	Байнга	Эрүүл мэндийн газар	Сумдын эрүүл мэндийн төв
43		Отроор яваа өрхийн 0-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн ахмад настны эрүүл мэндийн хяналтыг эрчимжүүлэх	-	-	Байнга	Эрүүл мэндийн газар	Сумдын эрүүл мэндийн төв
44		Отроор яваа өрхийн хүн, ам зүйн судалгааг нарийвчлан гаргах	-	-	Байнга	Эрүүл мэндийн газар	Сумдын эрүүл мэндийн төв
45		Отроор яваа малчдын хүүхдийг товлोलт вакцин, нөхөн вакцинжуулалтад заавал хамруулах, малчин өрхийн хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх	-	-	Байнга	Эрүүл мэндийн газар	Сумдын эрүүл мэндийн төв
46		Малчин өрхийн хүүхдүүд тэдгээрээс суралцагчдын судалгааг дэлгэрэнгүй гарган холбоо тогтоох харилцаа холбооны бэлэн байдлыг хангах, мэдээллийн сан байгуулах	-	-	Байнга	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	Боловсролын газар, Сумдын ЗДТГ
47	Отроор яваа малчид, зорилтот бүлгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах	Зудын эрсдэлтэй бүс нутаг болон отор нүүдлээр яваа өрхийн хүүхдүүдийг дотуур байранд бүрэн хамруулах зохион байгуулалттай арга хэмжээ авах	-	-	Байнга	Боловсролын газар	Сумдын ЗДТГ
48		Гамшгийн үед хүүхдийн эрэмблэн ангилалт хийж аюулгүй бүсрүү тээвэрлэх яаралтай тусламж үзүүлэх	-	-	Байнга	Гэр бүл хүүхэд залуучуудын	Боловсролын газар, Онцгой байдлын

1	2	3	4	5	6	7	8
49		Гамшгийн үед хүүхдийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд харьяалал харгалзахгүй сургах, үйлчилгээнд тасралтгүй хамруулах	-	-	Тухай бүр	хөгжлийн газар Боловсролын газар	газар, Сумдын ЗДТГ Сумдын ЗДТГ
Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр							
50	2024-2025 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурлан бодитой тогтоох, цаг агаарын мэдээ, гамшигт үзэгдлийн талаарх урьдчилан сэргийлэх мэдээг иргэд, малчдад түргэн шуурхай хүргэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн богино болон дунд хугацааны урьдчилсан мэдээ, цаг агаарын улирлын урьдчилсан төлөв байдлын талаарх мэдээ, мэдээллээр аж ахуй нэгж, байгууллага, ард иргэд, малчдыг тогтмол хангаж ажиллах	-	-	Байнга	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар
51	мэдээг иргэд, малчдад түргэн шуурхай хүргэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Өвөл, хаврын бэлчээрийн даацыг цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурлан бодитой тогтоох	-	Байгууллагын төсөв	09 дүгээр сар	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Сумдын цаг уурын ажилтан
Тайлагналт							
52	Хугацаанд нь чанартай, үр дүнтэй тайлагнах	Нарийвчилсан төлөвлөгөөний хяналтад авч хэрэгжүүлэн биелэлтийг чанартай, үр дүнтэй тайлагнан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлэх	-		IX/30	Хариуцсан бүх байгууллага, хэлтэс, агентлаг	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

ХЯНАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСНИЙ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.МАНДАЛ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСНИЙ ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Т.САРАНЧИМЭГ

